Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэн нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,304,992.0 мянган төгрөг, нийт зарлагыг 3,304,992.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 134,985.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 12,777.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 20,800.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 5,400.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 595,000.0 мянган төгрөгөөр, томилот, зочны зардлыг 47,240.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 47,162.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,650.0 мянган төгрөгөөр, нийт 870,014.5 мянган төгрөгөөр зардлыг бууруулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 135,443.4 мянган төгрөгөөр нэмж, 2,570,420.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь дээд шатны байгууллага төсвийн төслийг бууруулж баталснаас шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 202,604.2 мянган төгрөгөөр бууруулж 2,366,816.7 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн, 4 арга хэмжээг улсын төсвөөс 2,366,816.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,366,816.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн бус үйл ажиллагааны орлого 579,687.8 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, бараа ажил үйлчилгээний зардалд 2,254,489.9 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 300.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, улсын төсөвт 90,830.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,254,789.9 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 112,026.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71805	Шинжлэх ухаан, технологи	2,366,816.7	2,254,789.9	112,026.8	95.3%
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,360,620.7	2,248,593.9	112,026.8	95.3%
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	-	-	-	-
80802	Ажил олгогчоос олгох, тэтгэмж, урамшуулал, дэмждэг	300.0	300.0	-	100.0%
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх	5,896.0	5,896.0	-	100.0%

**1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар**

Тус хүрээлэн нь Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын дагуу бүтэц орон тоог 80 ажилтнаар баталсан ба Засгийн газрын чиглэлийн дагуу 9 хувиар бууруулах тогтоолын дагуу нөхөн томилгоо хийгдээгүй 71 ажилтан ажилласан байна.

**2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:**

Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол, захирлын 2024 оны А/01 тушаалын дагуу нэг өдрийн унаа 1.0 мянган төгрөг, хоолны хөнгөлөлтийг 29.0 мянган төгрөгөөр баталсан. Тайлант онд төсвийн төлөвлөгөөг 422,400.0 мянган төгрөгөөр төсөвлөж өгсөнийг бууруулж 200,927.0 мянган төгрөгөөр батлагдсан, гүйцэтгэлээр 354,100.3 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлтийг зарцуулсан байна.

**3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:**

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд 2,000.0 мянган төгрөгийг төсөвлөснөөс гүйцэтгэлээр залуу эрдэмтэн судлаачдын сургалтанд, дэлхийн итгэмжлэлийн өдрийн зөвлөгөөнд зарцуулсан байна.

Тайлант онд гадаад томилолт, арга хэмжээний зардал, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн зардал, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал тус тус гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба тайлант үеийн байдлаар арга хэмжээний хэрэгжилт 60 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 2026 оны 12 дугаар сард бүрэн дуусгахаар төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

*/мянган төгрөгөөр/*

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	"Морфологийн шинж чанар, ДНХ-ийн бар кодчиллын мэдээлэлд үндэслэн Монгол орны ойн экосистем дэх хортон шавьж болон ангуучин шавьж тодорхойлох" ГХТөсөл	2023 оны 1 сараас 2025 оны 12 сар хүртэл	-Монгол орны ойн экосистем дэх хортон болон ангуучин шавьжийн зүйлийн бүрэлдэхүүнийг морфологийн болон молекул биологийн аргаар нарийвчлан тогтооно. -ДНХ-ийн бар кодчиллын мэдээллийн сан бүрдүүлнэ.	Төслийн хэрэгжилт 100% 1. Судалгааны дээж цуглуулалт, лабораторийн шинжилгээ бүрэн хийгдсэн. 2. ДНХ бар кодын мэдээллийн сан бүрдүүлсэн.	54,000.0	54,000.0

			-Ойн хөнөөлт шавжтай тэмцэх шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллийн суурь бий болно.	3. Эцсийн тайлан боловсруулсан.		
2	"Хятад, Монгол 2 улсын хил дамнан нүүдэллэдэг зонхилох хөнөөлт шавьж /Нугын бор эрвээхэй/-д хяналт тавих, урьдчилан мэдээлэх менежмент боловсруулах" ГХТөсөл	2024 оны12 сараас 2026 оны 12 сар хүртэл	Нугын бор эрвээхэйн тархалт, нүүдлийн чиглэл, давтамжийг тогтооно. -Хил дамнасан хамтарсан хяналт-шинжилгээний механизм боловсруулна. -Урьдчилан мэдээлэх, эрсдэлийг үнэлэх загвар боловсруулж нэвтрүүлнэ. -Хөнөөлийг бууруулах менежментийн зөвлөмж, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна.	Төсөл 60% хэрэгжилттэй. 1. Судалгааны талбайн ажиглалт, мэдээлэл цуглуулалт хийгдсэн. 2.Урьдчилсан дүн шинжилгээ боловсруулсан. 3.Менежментийн загвар боловсруулах шатанд.	80,000.0	60,000.0
3	"Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд пестицидийн үлдэгдэл тодорхойлох судалгаа" суурь судалгааны төсөл	2024 оны 12 сараас 2026 оны 12 сар хүртэл	-Олон нэгдэлт пестицидийн үлдэгдэл тодорхойлох арга зүй баталгаажуулна. -Хүнс, ХАА-н бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн түвшинг тогтооно. -Стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлгээ өгнө. -Эрсдэлийн үнэлгээ хийж, хэрэглэгчийн аюулгүй байдлын талаарх мэдээллийн сан бүрдүүлнэ. -Пестицидийн зохистой хэрэглээг сайжруулах зөвлөмж боловсруулна.	Төсөл 60% хэрэгжилттэй. 1. Дээж цуглуулалт болон лабораторийн шинжилгээ хийгдсэн. 2. Үр дүнгийн боловсруулалт хийгдэж байна. 3. Эцсийн тайлан боловсруулах шатанд.	58,000.0	48,000.0

#### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь 2025 оны 02 дугаар сарын 03-наар худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг 9 нэр төрлийн бараа ажил, үйлчилгээнд 242,600.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж батлуулсан байна.

Гүйцэтгэлээр эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, нормын хувцас, зөөлөн эдлэл, бичиг хэргийн зардал, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, багаж, техник, хэрэгсэл, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл, урсгал засварт нийт 68 байгууллагатай гэрээ байгуулж, 226,408.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар хүний нөөцийн бүртгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Их Наяд Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Энхтуул, аудитор М.Мөнхзул нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Х.Ариунзул, Санхүүгийн аудитын газрын аудитор Ч.Мөнхбулган, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,681,483.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 26,814.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, албан томилолтоор онгоцоор явахад энгийн ангиллаар зорчих, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байх, ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалтыг гүйцэтгэх зэргээр хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийн 95.2 хувийг зарцуулж, 90,830.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой төлөвлөсөн горим сорилыг гүйцэтгэхэд тус хуулийг зөрчсөн асуудал аудитын явцад илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар илэрсэн нийт 17,630.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 1,455,25.9 мянган төгрөгийн 75 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд гарсан асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, зардал, орлогын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар 100,087.5 мянган төгрөгийн илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 55,501.4 мянган төгрөгийн 5 алдааг залруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 33,342.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 176.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг нотлох баримттай тулган шалгахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	33,342.3	1	33,342.3	100.0
Зөвлөмж	3	176.1	3	176.1	100.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>33,518.4</b>	<b>4</b>	<b>33,518.4</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын хэрэгжилт, санхүүгийн программд шинэчлэлийг бүрэн хийж төсвийн гүйцэтгэлийн болон тодруулга үнэн зөв гаргаж байгаа эсэхийг судлах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 62,233.2<sup>1</sup> мянган төгрөгийн 7 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Мөнгөн хөрөнгийн журналаас ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарлагыг данс андуурч бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй, УСНББОУС-2 “Мөнгөн гүйлгээний тайлан” болон “үнэн ба зөв” байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Бараа материалын дансанд хөрөнгийн шинж чанартай гүйлгээг бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-тай нийцэхгүй, УСНББОУС-12 “Бараа материал” болон “үнэн ба зөв” байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Бараа материалын дансанд орлогыг бүртгэхдээ тоо ширхэгийг бөөн дүнгээр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-тай нийцэхгүй, УСНББОУС-12 “Бараа материал” болон “үнэн ба зөв”, “тасалбар болголт” батламж мэдэгдлийг хангаагүй;
- Аж ахуйн материал дансанд бүртгэгдэх бараа материалыг өөр ангилалд буруу бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-тай нийцэхгүй, УСНББОУС-12 “Бараа материал” болон “үнэлгээ ба хувиарлалт” батламж мэдэгдлийг хангаагүй;
- Төсөл хөтөлбөрийн нэмэлт санхүүжилтийн орлогыг аккруэл сууриар бүртгээгүй, авлага үүсгээгүй ибаримтын орлогоос зөрсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцээгүй, УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, УСНББОУС-15 “Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга ба толилуулга” болон “иж бүрэн байх” “тасалбар болголт” батламж мэдэгдлийг хангаагүй;
- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тогтоолын шийдвэрийг програмд оруулахдаа ашиглах жилийг буруу оруулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 3.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцээгүй, УСНББОУС-7 “Үндсэн хөрөнгө” болон “үнэн ба зөв” батламж мэдэгдлийг хангаагүй;
- Аудитын төлбөр, интернетийн төлбөрийн өглөгийг дутуу бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцээгүй, УСНББОУС-19 “Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө” болон “тасалбар болголт”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар нийт 23,340.2 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 807.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 17,630.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 4,902.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 23,340.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,474.6 мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Баталсан орон тоонд багтах нэр бүхий 2 ажилтны үндсэн цалинг 1 дүгээр сард 357.9 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “*төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах*”, 16.5.2-т “*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*” гэж заасантай тус тус нийцэхгүй, “үнэн ба зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүрээлэнгийн нэр бүхий 2 ажилтанд 1 сард илүү тооцож олгосон цалинг буруутай албан тушаалтнаар төлүүлж, улсын төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт: Албан томилолтоор ажилласан хавсралтад дурдсан нэр бүхий 7 албан хаагчид унаа, хоолны хөнгөлөлтийг 450.0 мянган төгрөгөөр давхардуулан илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.1-д “*төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах*”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*” гэж заасантай тус тус нийцэхгүй, “үнэн ба зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчид унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосоныг буруутай албан тушаалтнаар төлүүлж, улсын төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Тус хүрээлэн нь бараа материалын худалдан авалт хийхдээ 5 байгууллагатай гэрээ байгуулаагүй 17,630.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан “нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар”, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан “зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, гэж заасантай нийцээгүй, “үнэн ба зөв”, “иж бүрэн” батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалт хийхдээ гэрээ, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бүх нийтээр амрах цагаан сарын баярын 3 өдөр ажилласан ажиллагсдыг хүний нөөц цаг бүртгэлийн системд бүртгэж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүний нөөцийн ажилтан цаг бүртгэлийн тайланг үнэн зөв ойлгомжтой хөтөлж, бүртгэл тайланг баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Мөнгөн хөрөнгийн журналаас ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарлагыг данс андуурч бүртгэсэн байна.	1	2,314.3			1	2,314.3	1	2,314.3				
2	Бараа материалд хөрөнгийн шинж чанартай гүйлгээг бүртгэсэн байна.	1	3,500.0			1	3,500.0	1	3,500.0				
3	Бараа материалын орлогыг бүртгэхдээ тоо ширхэгийг бөөн дүнгээр бүртгэсэн байна.	1	10,950.0			1	10,950.0	1	10,950.0				
4	Аж ахуйн материал дансанд бүртгэгдэх бараа материалыг өөр ангилалд буруу бүртгэсэн байна.	1	4,425.4			1	4,425.4	1	4,425.4				
5	Төсөл хөтөлбөрийн нэмэлт санхүүжилтийн орлогыг аккруэл сууриар бүртгээгүй, авлага үүсгээгүй ибаримтын орлогоос зөрсөн байна.	1	34,311.7			1	34,311.7	1	34,311.7				
6	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох тогтоолын шийдвэрийг програмд оруулахдаа ашиглах жилийг буруу оруулсан байна.	1	-			1	-	1	-				
7	Аудит, интернетийн төлбөрийн өглөгийг дутуу бүртгэсэн байна.	1	6,731.8	1	6,731.8			1	6,731.8				
	<b>Дүн</b>	<b>7</b>	<b>62,233.2</b>	<b>1</b>	<b>6,731.8</b>	<b>6</b>	<b>55,501.4</b>	<b>7</b>	<b>62,233.2</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал		
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж						
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
1	Баталсан орон тоон дээрх 2 ажилтны үндсэн цалинг 1 сард илүү бүртгэж олгосон байна.	1	357.9	1	357.9									
2	Албан томилолтоор явсан 7 албан хаагчид унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулж олгосон байна.	1	450.0	1	450.0									
3	Бүх нийтээр амрах цагаан сарын баярын 3 өдөр ажилласан ажиллагсдыг хүний нөөц цаг бүртгэлийн системд бүртгэж баталгаажуулаагүй байна.	1	4,902.3					1	4,902.3					
4	Бараа материал худалдан авалт хийхдээ 5 байгууллагатай гэрээ байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	17,630.0			1	17,630.0							
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>23,340.2</b>	<b>2</b>	<b>807.9</b>	<b>1</b>	<b>17,630.0</b>	<b>1</b>	<b>4,902.3</b>					



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 41/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/241/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Баталсан орон тоонд багтах хавсралтад дурдсан нэр бүхий 2 ажилтны үндсэн цалинг 1 дүгээр сард 357,916.55 /гурван зуун тавин долоон мянга есөн зуун арван зургаан төгрөг тавин таван мөнгө/ төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн нэр бүхий 2 ажилтанд 1 сард илүү тооцож олгосон 357,916.00 /гурван зуун тавин долоон мянга есөн зуун арван зургаан/ төгрөгийг Ерөнхий нягтлан бодогч Г.Энхжаргалаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал (М.Бямбасүрэн)-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Ari\2026\0225.SAG-21.Docx

152600095



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 40/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/241/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Албан томилолтоор ажилласан хавсралтад дурдсан нэр бүхий 7 албан хаагчид унаа, хоолны хөнгөлөлтийг 450,000.00 /дөрвөн зуун тавин мянган/ төгрөгөөр давхардуулан илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хавсралтад дурдсан 7 албан хаагчид давхардуулан олгосон унаа, хоолны хөнгөлөлтийг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ерөнхий нягтлан бодогч Г.Энхжаргалаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал (М.Бямбасүрэн)-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
Х.АРИУНЗУЛ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг-1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0225 SAG-21.Docx

1526160484



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 246/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/241/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус хүрээлэн нь бараа материалын худалдан авалт хийхдээ 5 байгууллагатай гэрээ байгуулаагүй 17,630,000.00 /арван долоон сая зургаан зуун гучин мянган/ төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан "нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар", энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан "зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалт хийхдээ гэрээ, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Захирал (М.Бямбасүрэн), ерөнхий нягтлан бодогч (Г.Энхжаргал) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага туйруу-3, Засагын газрын 4 дүгээр байр,  
Утас 51-2642310

9025107  
ATA10987  
9025021411

Z:\AlbanShaardlaga\2026\0125\SA15-271.docx

1526180531